

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ДУГААР 151011-1
ХАВСРАЛТ 1
ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

УТГА Компанийн 2021 оны тайлангийн талаарх
ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хурал ("Хурал")-ын шийдвэр болон Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралт ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА  А.ГАНХУЯГ



**СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГАРГАСАН ДҮГНЭЛТ**

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 болон Компанийн Дүрмийн 9.4.9-р заалтыг тус тус үндэслэн Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дараах дүгнэлтийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

2021 оны 11-р сард Компанийн хувьцааг олон нийтэд санал болгож шаардлагатай санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлж чадсан нь бизнесийн богино, дунд, цаашлаад урт хугацааны үр дүнд томоохон эерэг нөлөөг үзүүлэх үйл явдал болжээ. 2021 он коронавирусын өндөр тархалт, хөл хорио, тээвэр логистикийн гацаа, үнийн өсөлт зэрэг олон хүндрэл, асуудалтай жил байсан хэдий ч Компани хувьцаа эзэмшигчдэдээ амласандаа хүрч нийт 94 тэрбум төгрөгийн цэвэр борлуулалтын орлоготой ажиллаж төлөвлөгөөгөө 6.2 хувиар давуулан биелүүлсэн, цэвэр алдагдал 18 тэрбум төгрөгт хүрсэн нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн төлөвлөгөөнөөс 10 хувиар сайн гүйцэтгэлтэй гарсан. Мөн, СУ сүлжээ дэлгүүрийн тоог 63-р нэмэгдүүлж, тайлант оны эцэст өдөр бүр 60 мянган хүн үйлчлүүлдэг 165 салбар дэлгүүртэй болжээ.

Компани нь 2021 онд 1,855 хүнийг ажлын байраар хангаж, нийт 16 орчим тэрбум төгрөгийн цалин урамшууллыг олгосон байна. Мөн үйл ажиллагааны бүх шатанд байгаль орчин, нийгэм, засаглалын суурь үнэлгээг хийлгэсэн бөгөөд Олон Улсын Санхүүгийн Корпорацын Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт, конвенц, тунхаглал болон Монгол Улсын холбогдох хууль, стандарт, журамд заасан 182 шалгуур үзүүлэлтийг суурь үнэлгээ болгон авч үзсэнээс нийт 174 шалгуурыг бүрэн хангаж 95.6 хувийн биелэлттэй гарсан.

Иймд Компанийн Гүйцэтгэх удирдлагын баг 2021 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэж байна.

СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ДУГААР 151011-2
ХАВСРАЛТ 0
ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

УТГА Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дох заалт, 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хурал (“Хурал”)–ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө чөлөөлж ТУЗ–ийг шинэчилсэн бүрэлдэхүүнээр томилохоор шийдвэрлэсүгэй.
2. ТУЗ–ийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Адилбиш овогтой Ганхуяг,
 - (ii) Адилбиш овогтой Ганболд,
 - (iii) Гансүх овогтой Бат–Эрдэнэ,
 - (iv) Очирбат овогтой Батмөнх,
 - (v) Болдбаатар овогтой Бат–Эрдэнэ,
 - (vi) Ганболд овогтой Чинзориг.
3. ТУЗ–ийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Нямжав овогтой Энхболд,
 - (ii) Чулуун овогтой Мэргэн,
 - (iii) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo).
4. Компанийн ТУЗ–ийн гишүүдийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)–д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



А.ГАНХУЯГ